



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 0/115

Улаанбаатар хот

Барилга байгууламжийг байнгын ашиглалтад  
комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 15.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм", тус газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.4.1.1 дэх заалтад тусгасан "Үүрэн телефоны сүлжээ дамжуулах станц /Увс, Ховд сум/ - ТШ:ХХМТГ/202001002", IV.4.1.2 дахь заалтад тусгасан "Үүрэн телефоны сүлжээ дамжуулах станц /Ховд, Дөргөн сум/ - ТШ:ХХМТГ/202001004", IV.4.1.5 дахь заалтад тусгасан "Харилцаа холбооны дахин дамжуулах станц /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/ - ТШ:ХХМТГ/202001003" IV.4.1.6 дахь заалтад тусгасан "Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ - ТШ:ХХМТГ/202001005", IV.4.3.1 дэх заалтад тусгасан "Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем /улсын хэмжээнд/ - ТШ:ХХМТГ/201912003" төслийн хүрээнд хийгдсэн холбооны барилга байгууламж болон их засвар, шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийг хянах, байнгын ашиглалтад хүлээж авах Улсын комиссын бүрэлдэхүүнд захиалагч талыг төлөөлөн ажиллахаар Харилцаа холбоо, шуудангийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Батбаяр, мэргэжилтэн Ш.Самданжамц нарыг томилсугай.

2. Шинэ барилга, цамхаг суурилуулалт, их засварын ажлын гүйцэтгэлийг хянах, ажлын гүйцэтгэлд зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг тэмдэглэж, зөрчлийг шуурхай арилгуулах үүргийг гүйцэтгэгч талд өгөх, Улсын комисс барилга байгууламжийг үүрэг, даалгавартайгаар хүлээж авах эсхүл барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авахаас татгалзахаар шийдвэрлэх тохиолдолд түүнийг тухай бүр байгууллагын удирдлагад танилцуулж байхыг Д.Батбаяр, Ш.Самданжамц нарт даалгасугай.

3. Тушаалын 1-д заасан төслүүдийг байнгын ашиглалтад хүлээж авах комисс ажиллах бүрд шаардагдах томилолтын зардлыг холбогдох төслийн захиалагчийн хяналтын зардлаас шийдвэрлэхийг Ерөнхий нягтлан бодогч /О.Наранбаатар/ -т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Батлав:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга

Б.Болор-Эрдэнэ

Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах томилолтын зардал  
/Өвөрхангай аймаг, Баянхонгор аймаг/

№	Комиссын гишүүд	Зам, хоногийн зардал (₮)	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал /₮/
1	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын дарга	14,000	7	98,000
2	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын мэргэжилтэн	14,000	7	98,000
3	Жолооч	14,000	7	98,000
				<b>294,000</b>

№	Комиссын гишүүд	Байрны зардал (₮)	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал /₮/
1	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын дарга	36,000	7	252,000
2	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын мэргэжилтэн	36,000	7	252,000
3	Жолооч	36,000	7	252,000
				<b>756,000</b>

№	Хаанаас	Хаана	Явах зай /км/	Шатахууны зардал /₮/
1	Улаанбаатар хот	Арвайхээр, Өвөрхангай	438	192,720
2	Арвайхээр - Тарагт - Арвайхээр		70	30,800
3	Арвайхээр - Зүүн Баян улаан - Арвайхээр		90	39,600
4	Арвайхээр - Бүрд - Арвайхээр		220	96,800
5	Арвайхээр, Өвөрхангай	Баянхонгор	200	88,000
6	Баянхонгор - Баянлиг - Баянхонгор		428	188,320
7	Баянхонгор - Баян Өндөр - Баянхонгор		538	236,720
8	Баянхонгор - Галуут - Баянхонгор		160	70,400
9	Баянхонгор - Шинэжинст - Баянхонгор		488	214,720
10	Баянхонгор - Заг - Баянхонгор		366	161,040
11	Баянхонгор	Улаанбаатар	635	279,400
12	сул явалт	сул явалт	100	44,000
			<b>Нийт</b>	<b>3,733</b>
				<b>1,642,520</b>

№	Түрээсээр ажиллах машин	Түрээсээр ажилах өдөр	Өдрийн хөлс	Нийт дүн
1	Тоёота Ланд Круйзер	8	300,000	2,400,000

			<b>Бүгд зардал (₮)</b>	<b>5,092,520</b>
--	--	--	------------------------	------------------

Дээрх зардлыг холбогдох төслийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

Тооцоолол хийсэн:

Харлцаа холбоо, мэдээллийн технологийн газрын

Ерөнхий нягтлан:

О.Наранбаатар

Батлав:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга



Б.Болор-Эрдэнэ

Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах томилолтын зардал  
/Увс аймаг, Булган аймаг/

№	Комиссын гишүүд	Зам, хоногийн зардал (₮)	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал /₮/
1	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын дарга	14,000	8	112,000
2	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын мэргэжилтэн	14,000	8	112,000
3	Жолооч	14,000	8	112,000
				<b>336,000</b>

№	Комиссын гишүүд	Байрны зардал (₮)	Томилолтоор ажиллах хоног	Томилолтын зардал /₮/
1	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын дарга	36,000	8	288,000
2	ХХМТГ-ын ХХШБЗГ-ын мэргэжилтэн	36,000	8	288,000
3	Жолооч	36,000	8	288,000
				<b>864,000</b>

№	Хаанаас	Хаана	Явах зай /км/	Шатахууны зардал /₮/
1	Улаанбаатар хот	Улаангом, Увс	1,375	605,000
2	Улаангом	Тэс	310	136,400
3	Улаангом	Ховд	354	155,760
4	Улаангом	Зүүнговь	278	122,320
5	Улаангом	Завхан	322	141,680
6	Улаангом	Өлгий	226	99,440
7	Улаангом	Бөхмөрөн	368	161,920
9	Улаангом	Цагаанхайрхан	452	198,880
10	Улаангом	Булган	1,000	440,000
11	Булган	Сэлэнгэ	262	115,280
12	Булган	Хангал	226	99,440
13	Булган	Гурванбулаг	280	123,200
14	Булган	Улаанбаатар хот	388	170,720
15	сул явалт	сул явалт	250	110,000
Нийт			<b>6,091</b>	<b>2,680,040</b>

№	Түрээсээр ажиллах машин	Түрээсээр ажилах өдөр	Өдрийн хөлс	Нийт дүн
1	Тоёота Ланд Круйзер	9	300,000	2,700,000

			<b>Бүгд зардал (₮)</b>	<b>6,580,040</b>
--	--	--	------------------------	------------------

Дээрх зардлыг холбогдох төслийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлнэ.

Тооцоолол хийсэн:

Харлцаа холбоо, мэдээллийн технологийн газрын  
Ерөнхий нягтлан:

О.Наранбаатар